



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 24 өдөр

Дугаар 16

Хэрлэн сум

XVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 16 дугаар хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 68,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих түр хяналтын цэгийг Хөлөнбуйр суманд байгуулах талаар хэлэлцэх,

Мал эмнэлгийн газар

2. Тус аймагт 2023 оны 03, 04 дүгээр сард гарсан хээрийн түймэр унтраах үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны зардлыг танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

3. Дашбалбар, Чойбалсан, Чулуунхороот суманд гарсан хээрийн түймэр унтраахад дайчлагдаж ажилласан автомашиныг засварлахад шаардагдах зардлын тооцоог танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4. Дорнод аймагт 2023 оны 05 дугаар сард тохиолдсон цаг агаарын аюулт үзэгдэлд өртсөн иргэдэд Улсын нөөцийн газраас олгосон тусламжийг тээвэрлэсэн автомашины буцах шатахууны зардлыг танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1. Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих түр хяналтын цэгийг Хөлөнбуйр суманд байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

/  / Ш.Ёл
/  / х/ч Б.Цогтбаяр

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

1.2. Малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих түр хяналтын цэгийг Хөлөнбуйр суманд байгуулахад шаардагдах 2,752,954 төгрөгийн зардлыг хянаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Хоёр.Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1. Дорнод аймагт 2023 оны 03, 04 дүгээр сард гарсан 16 удаагийн хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны 11,875,658 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хянуулж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Гурав.Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Дашбалбар, Чойбалсан, Чулуунхороот суманд гарсан хээрийн түймэр унтраахад дайчлагдаж ажилласан шуурхай албаны 01-05 ДОО улсын дугаартай автомашиныг засварлахад шаардагдах 4,225,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хянуулж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Дөрөв.Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Дорнод аймагт 2023 оны 05 дугаар сард тохиолдсон цаг агаарын аюулт үзэгдэлд өртсөн иргэдэд Улсын нөөцийн газраас олгосон тусламжийг тээвэрлэсэн автомашины буцах шатахууны 766,500 төгрөгийн зардлыг аймгийн Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас олгохыг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР